

Агуулга

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийг хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:.....	3
1.2 Төслүүдийн байршил:	3
1.3. Төслүүдийн нэр:.....	3
1.4. Ашиглах технологи:	3
1.5. Үйлдвэрлэх бүтээгдэхүүн:	6
1.6. Төслүүдийн хүчин чадал:.....	6
1.7. Үндсэн түүхий эд, туслах материал, түүний хангамж:	6
1.8. Борлуулах зах зээл:	6
1.9. Түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэх шийдэл	6
1.10. Эрчим хүч, усан хангамж:	6
1.11. Эдийн засаг, нийгмийн ач холбогдол:	7
1.12. Дэд бүтэц, авто замын талаар:.....	7
1.13. Уурхайн үргэлжлэх хугацаа:	7
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
3.1. Арга зүй:	9
3.2. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл:	9
3.2.1. Хийн бохирдол:.....	9
3.2.2. Дуу чимээний бохирдол:.....	9
3.2.3. Тоос:.....	10
3.2.4. Орчны эрүүл ахуйн чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:.....	10
3.3. Төслийн гол сөрөг нөлөөлөл:	11
3.3.1. Геологийн тогтоц, газрын гадарга, хэвлийд нөлөөлөх:	12
3.3.2. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх:	12
3.3.3. Ургамлан нөмрөгт нөлөөлөх:	12
3.3.4. Агаар орчинд нөлөөлөх:	13
3.3.5. Усны нөөц , чанарт нөлөөлөх:	13
3.3.6. Амьтны аймагт нөлөөлөх:	14
3.4. Нийгэм эдийн засагт нөлөөлөх:	14
3.5. Өрөмдлөг-тэсэлгээний ажил:	15
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	16
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
АРВАН НЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	20
АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
ХАВСРАЛТ	23

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийг хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:

“ОЧИР ТӨВ” ХХК нь 2011003076 тоот улсын бүртгэлийн дугаартай, 2031256 тоот регистрийн дугаартай Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж бөгөөд 2011 оноос олборлолт болон үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж байгаа компани юм. Тус компани нь MV-012161 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших “Тасагийн Овоо” барилгын чулууны ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ мөн бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/ төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн.

1.2. Төслүүдийн байршил:

“Тасагийн овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/ нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт, Эрдэнэт хотоос зүүн зүгт 12 км-т Хангал голын хойт уулын өвөр бэлд байрлана.

Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/ нь Орхон аймаг, Баян - Өндөр сум /Эрдэнэт хот/ Говил багийн нутаг дэвсгэрт байрладаг.

1.3. Төслүүдийн нэр:

- “Тасагийн Овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/
- Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/

1.4. Ашиглалтын систем:

Ил уурхайн ашиглалтын систем:

“Тасагийн Овоо” барилгын чулууны ордын чулуулгийг өрөмдлөг-тэсэлгээтэй, экскаватор-автосамосвалын хослол бүхий авто тээвэртэй ашиглалтын системээр уулын ажлыг явуулахаар сонгов.

Уулын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмжүүд:

Хүснэгт 1.1

д/д	Тоног төхөөрөмжийн нэр		Хүчин чадал, багтаамж		Тоо, ширхэг
	Төрөл	Марк	Нэгж	Хэмжээ	
1	Экскаватор	Kobelco SK230	м³	1.0	1
2	Утгуурт ачигч	ZL50E	м³	3	1
3	Автосамосвал	North Benz	м³	16	2
4	Бульдозер	Б10	кВт	130	1

Өрөмдлөг-тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хийлгэдэг.

Бутлан ангилах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд:

Хүснэгт 1.2

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Үйлдвэрлэсэн улс	Хэмжих нэгж	Тоо, ш	Хүчин чадал
1	Доргиурт тэжээгч	Хятад	т/цаг	1	120-210
2	Хацарт бутлуур	Хятад	т/цаг	1	60-130
3	Цохилтот бутлуур	Хятад	т/цаг	2	100-160
4	Чичиргээт шигшүүр	Хятад	т/цаг	1	100-400
5	Конвейер B=500, L=10м	Хятад	т/цаг	1	40
6	Конвейер B=800, L=9м	Хятад	т/цаг	1	70
7	Конвейер B=800, L=21м	Хятад	т/цаг	2	130
8	Конвейер B=800, L=23м	Хятад	т/цаг	1	130
9	Конвейер B=650, L=15м	Хятад	т/цаг	3	70



Зураг-1. Тоног төхөөрөмжүүдийн холболтын бүдүүвч

Бетон зуурмагийн үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд:

Хүснэгт 1.3

Үйлдвэрлэлийн дамжлага	Тоног төхөөрөмж	Техникийн тодорхойлолт	Үзүүлэлт
Түүхий эд материалын агуулах	Өөрөө ачигч	Шанаганы багтаамж	2,5м ³
	Элсний агуулах	Эзлэхүүн	500м ²
	5-10,10-20мм-н дайрганы агуулах	Эзлэхүүн	240м ²
	дамжуулагч бункер	Хайрганы бункер	16м ³ х2шт
		Элсний бункер	16м ³ х2шт
		Жинлэгч бункер	3м ³ х4шт
		Туузан дамжуулагч	800 мм
		Хөдөлгүүрт дамар	15 квт
		Вибратор	MVE 200/3
	Цөментийн силос	Эзлэхүүн	100тн х 2шт
		Эзлэхүүн	200 тн х 1 шт
		Шурган дамжуулагч Ф 320мм	8м х3шт
		Хөдөлгүүр	7,5 квт х 3шт
	Технологийн усны нөөцийн сав	Эзлэхүүн/насос	25тн/5,5квт
	Химийн нэмэлтийн нөөцийн сав	Эзлэхүүн/насос	6м3/2,2квт
Түүхий эдийг зөөвөрлөх, хэмжих	Туузан дамжуулагч (3)	Туузны урт туузны өргөн Хөдөлгүүр	75м 800мм 7,5 квт
	налуу туузан дамжуулагч /налуу/, (4)	Туузны урт туузны өргөн Хөдөлгүүр	80м 800мм 30квт
	WG8 хийн шахуургат цемент шахагч	Компрессор Вй\Л/6/2 Хөдөлгүүрийн чадал Шахах хий,	18,5 кв/ 0,2Мра
	Усны гүний насос	Гүйдлийн чадал	40 А
	Ус дамжуулах насос	Гүйдлийн чадал	65 А
	нэмэлт дамжуулах насос	Хоолойн насос Эргэлтийн насос	2,2квт 0,75 квт
	Нэмэлтийн тугнуур	Эзлэхүүн	40кг
Бетон зуурмаг бэлтгэх	Усны тугнуур	Эзлэхүүн	1 тн
	Цементийн завсрын бункер	Эзлэхүүн	2тн
	Дүүргэгчийн завсрын бункер	Эзлэхүүн	3м ³
	Зуурагч MAO2250/150030	Эзлэхүүн	1,5 м ³
		Хөдөлгүүрийн чадал	30 квт
		Тосолгооны насос	20л
		Хөдөлгүүрийн чадал	1 квт
	Юүлэх бункер	Хөдөлгүүрийн чадал	1 квт

1.5. Үйлдвэрлэх бүтээгдэхүүн:

- Барилгын чулуу олборлож, дайрга үйлдвэрлэх
- М100 - М400 хүртэл маркын бетон зуурмаг үйлдвэрлэх

1.6. Төслүүдийн хүчин чадал:

- Уурхайн жилд 100,0 мян.м³ барилгын чулуу олборлож бутлан ангилах хүчин чадалтай
- Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/ цагт 90 м³ бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай.

1.7. Үндсэн түүхий эд, туслах материал, түүний хангамж:

1. Цементийг Хөтөлийн "Цемент - Шохой" ХХК болон Дархан хотын "Эрэл" ХХК – иас авдаг.

2. 5-10 мм, 10-20 мм-ийн дайргыг өөрийн "Тасагийн овоо"-ны дайрганы үйлдвэрээс авдаг.

3. Элс хайрганы холимог ПГС-г Дархан Уул аймгийн "Түшиг Уул" ХХК - ийн үйлдвэрээс авдаг.

4. Бетон зуурмагийг уян налархайжуулах, хөдөлгөөнт чанарыг хадгалах, бэхжилтийг түргэсгэх зорилгоор Sika ViskoGrete 5510 MN болон бетон зуурмагт усны хамгаалалтыг сайжруулж ус үл нэвтрүүлэх чанарыг дээшлүүлэх, бат бэхийг хангахад Sika Visko Tight MN нэмэлтүүдийг "Сика Монголиа" ХХК- иас 1 тн-ын хуванцар саваар шингэн байдлаар авдаг.

1.8. Борлуулах зах зээл:

Хувь хүн болон барилгын компаниудад нийлүүлэнэ.

1.9. Түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэх шийдэл

Компани өөрийн болон захиалагчид өөрийн техник хэрэгслээр тээвэрлэнэ.

1.10. Эрчим хүч, усан хангамж:

Орхон аймгийн цахилгаан түгээх шугам сүлжээний ЦРП-7 станцын ячейк №20-с уурхайн аж ахуйн байр болон тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийг эрчим хүчээр хангадаг.

Уурхай нь түүхий эд бүтээгдэхүүнээ хуурай аргаар бутлан ангилж үйлдвэрлэдэг учир технологийн дамжлагатаа ус хэрэглэдэггүй харин унд ахуйн хэрэгцээнд шаардлагатай усыг өдөр бүр гүний худгаас зөөвөрлөн хэрэглэж байна.

Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/ нь материал хангамжийн баазын талбайд байх ба 400 кв-ын трансформатороос тэжээгддэг болон шаардлагатай үед "Дамжуулах байгууламж"-аас шууд цахилгаанаар хангагддаг.

Үйлдвэрлэлийн технологийн болон ахуйн хэрэгцээний усаа өөрийн гүний худгаас авдаг.

1.11. Эдийн засаг, нийгмийн ач холбогдол:

Уг төслөөс нийгэм эдийн засагт тодорхой хэмжээний ажлын байр бий болох, орон нутагт зам барилгын ажил гүйцэтгэж буй компаниудын барилгын материалын голлох түүхий эд хайрга дайрга, бетон зуурмагийг чанартай үйлдвэрлэж ханган нийлүүлснээр орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, улсын төсөвт тодорхой хэмжээний татвар шимтгэлийг хуулийн дагуу төлөх зэргээр эерэг нөлөө үзүүлнэ.

1.12. Дэд бүтэц, авто замын талаар:

Уурхай нь Эрдэнэт хотоос зүүн зүгт байрлах бөгөөд Дархан-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын дагуу орших учир төв замыг ашиглан тээвэрлэлт хийнэ. Харин төв замаас уурхай хүртэлх 1,2 км зайд шороон замаар явах бөгөөд уг замыг жил бүр автогрейдерээр хусаж цэвэрлэн засч тэмдэгжүүлэн аюул осолгүй тээвэрлэлт хийх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

1.13. Уурхайн үргэлжлэх хугацаа:

MV-012161 тоот тусгай зөвшөөрлийн нийт 25 га талбайд нөөц нэмэгдүүлсэн ба 2024 оны 1 сарын 1-ний байдлаар 5365.51 мян.м³ үйлдвэрлэлийн нөөц байгаа ба жилд 100.0 мян.м³ борлуулан гэж үзэхэд уурхайн 54 жилийн хугацаанд ажиллана.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газар зүйн хувьд: Газрын гадаргын хувьд Орхон Сэлэнгийн хөндийд Эрдэнэтийн Овоо ордын зүүн хойд талд өргөрөгийн 49°05'11", уртрагийн 104°10'15"-д оршино. Уулсын харьцангуй өндөржилт далайн түвшнээс дээш 1700-1200м-т хэлбэлзэнэ. Гадаргуугийн рельефийн байдал ерөнхийдөө уулархаг, голын урсгалын дагуу баруунаас зүүн тийш намссан байдаг.

Усан сүлжээний хувьд: Уг ордын дүүргийн хувьд Орхон Сэлэнгийн хотгорт орших бөгөөд гадаргын усан сүлжээ сайтай, ордын эргэн тойронд Эрдэнэтийн, Хангалын гэх мэт жижиг голуудтай эдгээр голууд нь хур борооны

усаар тэжээгдэх бөгөөд цаашид Орхон голд цутгадаг.

Ургамалжилт болон амьтны аймаг: Нутгийн ургамлын хувьд талархаг нутгийн шинжтэй. Шинэс, нарс, хус, хуш, улиас модоор хязгаарлагдмал, голдуу уулархаг газрын ар өврөөр тархсан. Ан амьтдаас төрөл бүрийн жигүүртэн цувууд, араатан амьтад, чоно, үнэг, баавгай, туулай, хярс элбэгтэй.

Цаг уурын төлөв байдал: Нутгийн цаг агаар ердийн эх газрын, нэг дүгээр сарын дундаж температур хасах 14-16°, 7 сарынх нэмэх 15-18°. Сүүлийн 15 жилийн ажиглалтаар жилийн дундаж тунадас 370мм (үүний 86% зуны улиралд хамаарна) жилдээ 241-599мм хэлбэлзэлтэй. Цасан бүрхүүлийн дундаж зузаан 5см, хамгийн их үедээ 25см. Бүс нутгийн хэмжээнд, ялангуяа ойгоор бүрхэгдсэн өндөрлөг газруудын хойт хэсгээр эх газрын хөлдөлт ихтэй. Улирлын хөлдөлтийн гүн 5-6 м. Жилийн дундаж харьцангуй агаарын чийг - 65%. Салхины зүг, хүч улирлуудаас хамаарч янз бүр: өвөл салхи хүчгүй, заримдаа салхигүй, хавар, зун салхины чиг, хүч өөрчлөлт ихтэй, шороон шуурга багагүй болдог байна.

Нийгэм эдийн засаг: Хүн ам их суурьшсан газар нь Эрдэнэт хот (80000 хүн амтай), Булган аймгийн төв (ордоос баруун тийш 65 км, 30000 хүн амтай) юм.

Эрдэнэт хотоос хойш 185 км-т үйлдвэрийн төв өөрийн эрчим хүч, барилгын баазтай, тээврийн том сүлжээтэй Дархан хот оршдог (90000 хүн амтай). Эрдэнэт хот нь Монгол орны аж үйлдвэрийн гол бүс нутаг юм. Энд Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" зэс-молибдений баяжуулах үйлдвэр, бетоны, асфальт-бетоны завод, төмөр-бетоны болон бусад үйлдвэрүүд ажилладаг.

Хотын болон УБҮ-ийн барилгын материалын гол хэрэгцээг Дархан, Хөтөл хотоос хангадаг.

Зам харилцааны хувьд харьцангуй сайн, Улаанбаатар хот, Дархан, Хөтөл, Булган зэрэг томоохон хот суурин газруудтай хатуу хучилттай авто замаар холбогддог.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Арга зүй

"Очир Төв" ХХК-ийн "Тасагийн овоо" уурхай /бутлан ангилах үйлдвэр/ болон бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/-н байгаль орчинд нөлөөлөх байдлын болзошгүй болон голлох нөлөөллийн үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол улсын хууль, Байгаль орчны яамнаас гаргасан аргачлал, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос гаргасан магадлан жагсаах болон матрицын арга зэргийг ашиглан гаргадаг.

3.2. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.2.1. Хийн бохирдол

Тээврийн хэрэгсэлийн утааны найрлага болон түлшний шаталтын бүтээгдэхүүнээс хүрээлэн буй орчин, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ, цар хүрээ хамаарч байдаг. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулдаг байна.

3.2.2. Дуу чимээний бохирдол

Төсөл хэрэгжих бүс нутгийн жилийн дундаж салхины хурд 2 м/сек байна. Харин 1.5м/с буюу түүнээс бага хурдтай зөөлөн сэвэлзүүр салхи дуу чимээг өсгөж байдаг. Түүнээс өндөр хурдтай салхи дуу авиаг гаргаж байгаа эх үүсгүүрийн чимээний түвшинг өсгөдөг. Чимээ шуугианы эх үүсгэвэр нь авто машин, механизмуудаас гардаг. Хүснэгт 2.1-д үзүүлэв.

Чимээ шуугианы үндсэн эх үүсвэр, дБ

Хүснэгт 2.1

№	Нэрс	Тоо	дБ
1	Экскаватор SK230	1	76
2	Автосамосвал North-Benz	2	82
3	ZL-50E ачигч	1	80
4	PE-600x900 хацарт бутлуур	1	100
5	PF-1214 цохилтот бутлуур	2	
6	ЗҮК-2160 чичиргээт шигшүүр	1	
7	Туузан дамжуурга	8	

Хот суурин газрын хүрээлэн буй агаарын чанарын Монгол улсын стандарт (MNS 4585:2007)-д зааснаар өдрийн цагаар 60дБ, шөнийн цагаар 40дБ хэмжээнээс ихгүй байхаар тогтоосон байдаг байна. Төсөл хэрэгжих газар нь Эрдэнэт хотоос зүүн зүгт 12 км зайд байрлах тул дуу чимээний нөлөөлөл агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй гэж үзлээ.

3.2.3. Тоос

Тоосжилт нь уурхай болон бетон зуурмагийн үйлдвэрийн орчны агаарын бохирдолтонд нөлөөлдөг хамгийн түгээмэл тулгардаг асуудал юм. Дараах нөхцөл байдлыг улмаас үйлвэрийн орчинд тоосжилт үүсч байна.

- тэслэлт, олборлолт, тээвэрлэлт, ачилт, буулгалт
- бутлан ангилах үйлдвэр ажиллах үед
- хатуу хучилт хийгдээгүй шороон замаар тээвэр хийх

3.2.4. Орчны эрүүл ахуйн чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

Ахуйн хог хаягдал.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах үед байгаль орчны төлөв байдалд үзүүлж болох болзошгүй сөрөг нөлөөлөл нь ахуйн хог хаягдал байна.

- Хатуу хог хаягдал
- Шингэн хог хаягдал
- Хийн хаягдал

Хатуу хог хаягдал.

Үүнд 1 хүнээс өдөрт дундажаар 0.2 кг хатуу хог хаягдал гардаг байна. Хатуу хог хаягдлын эх үүсвэр ажилчдын хэрэглээ, хоол хүсний үлдэгдэл байх болно. Хатуу хог хаягдлын дийлэнх хувийг сав баглаа боодол эзэлнэ. Доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гарахаар байна. Үүнд:

1. Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол
2. Бие засах газрын хаягдал
3. Ундааны сав, лааз болон бусад хаягдал
4. Хоолны үлдэгдэл
5. Бусад

Хэрэв болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж чадвал байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл үүсэхгүй байж болно.

Шингэн хог хаягдал.

Төслүүдийн үйл ажиллагаанаас хаягдал ус гарахгүй. Ажилчид гар нүүр угаах, шүршүүрт орох, хоолны үлдэгдэл бохир, аяга таваг болон ахуйн эд зүйлсийн угаалга, бие засах газар зэргээс бохир ус ялгарч гарна. Эндээс гарсан хаягдал, бохир усны найрлага нь байгаль орчинд онц хохирол учруулахуйц хортой биш бөгөөд саван, угаалгын нунтаг болон аяга таваг угаахад хэрэглэгдэх бодисуудыг эс тооцвол органик бодис голлосон найрлагатай байдаг байна.

Хийн хаягдал.

Хийн хаягдал үүсэх гол эх үүсвэр нь автомашины утаа болно. Агаар орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь ажилчдын ирэх болон буцах тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн хөдөлгүүрээс ялгарах утааны найрлагаас бохирдох нөхцөлтэй.

Агаарын бохирдол, ялангуяа химийн бохирдол нь автомашины түлшний шаталтын бүтээгдэхүүнээс шууд шалтгаалж байдаг. Автомашинаас хүрээлэн буй орчин, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ, цар хүрээ нь түүний утааны найрлагаас шууд хамаарч байдаг. Автомашины утааны найрлага нь олон зүйлсээс хамаарч байдаг. Тухайлбал:

- Хөдлөх бүрэлдэхүүний тоо
- Хөдөлгүүрийн чанар, техникийн байдал
- Түлшний найрлага шинж чанар
- Хөдөлгүүрийн ажиллагааны горим

зэрэг хүчин зүйлсээс хамаарч харилцан адилгүй хэмжээ, үйлчлэлтэй байдаг онцлогтой. Автомашины хөдөлгүүр бол химийн нэгдмэл хорт бодис ялгаруулах нэгэн төрлийн химийн реактор билээ. Энэхүү химийн реактор-хөдөлгүүрийн чанар хэдий хэр муудсан байна ялгаруулах хорт нэгдэл нь төдий хэрээр нэмэгддэг.

3.3. ТӨСЛИЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Газрын хэвлийгээс ашигт малтмалыг олборлох бүх арга технологиуд газар ба түүний хэвлийг хөндөж, экологийн тэнцвэртэй байдалд шууд ба дам байдлаар төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд их эрчимтэйгээр нөлөөлдөг онцлогтой. Голлох сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлон үзүүлэв. Үүнд:

3.3.1. Геологийн тогтоц, газрын гадарга, хэвлийд нөлөөлөх

“Очир Төв” ХХК-ийн Тасагийн Овоо барилгын чулууны /дайрганы/ ордыг ил аргаар ашиглах учир уурхайн үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд дараах байдлаар шууд нөлөөлнө.

Үүнд:

- Газрын хэвлий ухагдан онгилогдож ландшафтын хэлбэр дүрс өөрчлөгдөн байгалийн унаган төрх алдагдаж 480.4 м урттай, 450.0 м өргөнтэй, 45 м гүнтэй ил уурхайн хоосон орон зай үүснэ.

- Ил уурхайн үйл ажиллагаар газрын хэвлийгээс 5365.51 мян.м³ барилгын чулуу олборлогдоно.

3.3.2. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх

“Тасагийн овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/ болон бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/-ын зүгээс хягдал бохир ус, ахуйн болон хатуу хог хаягдал гэх зэргээр хөрсийг бохирдуулж, хөрсний бүтцэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс бага байна. Харин автомашины үйл ажиллагаанаас болж хөрсөн бүрхэвчид дараах сөрөг нөлөөллүүд үүсэх боломжтой. Үүнд:

- Авто зам орчмын хөрс техноген бохирдолд өртөх
- Механик үйлчлэлээр (машины дугуй, хүний хөл) талхлагдаж сийрэгжих, нимгэрэх
- Хог ургамалд баригдах, доройтох
- Хөрс салхинд хийсч элэгдэж эвдрэх үйл явц нь ихсэн тоосжилт нэмэгдэх зэрэг болно.
- Машин техникийн шатах, тослох материал алдагдах нь хөрсний бохирдолыг үүсгэнэ.

3.3.3. Ургамлан нөмрөгт нөлөөлөх

“Тасагийн овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/

“Очир төв” ХХК-ний лицензийн талбай орчмын газар нь Бүрэнгийн нурууны салбар уулс болох Бүхэнгийн нурууны зүүн урд хэсэгт нам гүвээ, толгод бүхий газарт д.т.д 1220-1230м өндөртэй хэсэгт байрладаг. Энэ газар нь хээрийн экосистемийн иж бүрдэлтэй, суурин газартай ойр учир бэлчээрт нилээн талхлагдсан, зогдор улалж оролцсон гичгэнэ-алаг өвст болон чулуурхаг алаг өвс-гичгэнэ-хялганат бүлгэмдэл зонхилсон сийрэгдүү ургамлан нөмрөгтэй байна.

Үйлдвэрлэлийн талбай орчмын эвдрээгүй газрын ургамлан нөмрөг машин техникийн замын нөлөөгөөр доройтолд бага орсон, харин суурин газрын

ойролцоо учир малын талхлах нөлөө илэрсэн. Машины зогсоол болон замд ашиглагдсан газрын ургамал бүрхэвч 50-100%, ашиглаж буй талбайн ургамал 90-100% тус тус алдарч доройтсон байна.

Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/

Үйлдвэрийн газарт ихэвчлэн шарилж, хаг гэх мэтийн ургамал ургах бөгөөд хөрс нь гадны нөлөөлөлд хэврэг, тоос шороо дэгдэмхий саарал шороо босох талтай. Тухайн газар, орчин дахь ургамлан нөмрөгт үзүүлэх голлох нөлөөлөл нь бетон зуурмагийн үйлдвэрийн авто машины хөдөлгөөний улмаас үүссэн тоос, тоосонцороос шалтгаалан ургамлын ургалт муудах юм. Үүнийг арилгах тал дээр үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаанаас үүсэх тоосны хэмжээг багасгахын тулд тоосжилт ихтэй саруудад гадна зам талбайг тогтмол чийгшүүлэх болон үйлдвэрийн аюулгүй бүрэн бүтэн ажиллагааг хангах ажлуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн үйлдвэрийн эргэн тойрон дахь талбайн ургамал тоосжилтоос болж бохирдох тул үйлдвэрийн эргэн тойрон дахь талбайг ургамалжуулах шаардлагатай. Тухайн орчинд ажиллаж буй автомашин, механизмуудын тос, тослох бүтээгдэхүүн асгарснаас ургамал, хөрс бохирдох тул авто засварын шаардлагад нийцсан хатуу хучилттай тусгай цэгтэй байна.

3.3.4. Агаар орчинд нөлөөлөх

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тэсэлгээ, бутлан ангилан үйлдвэр ажиллах үед түүхий эд материалыг ачих, буулгах, тээвэр хийх зэрэг үйл ажиллагаанаас агаарт тархах тоос шороо болно. Иймд цаашид тоосжилтын хэмжээг бууруулахын тулд үйлдвэрийн орчинд усалгаа, чийгшил тогтмол хийж, мөн түүнээс урьдчилан сэргийлэх арга, техникийг боловсруулж ажиллах нь зүйтэй.

3.3.5. Усны нөөц, чанарт нөлөөлөх

“Тасагийн овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/

Тус дайрганы уурхайн орд газрын орчим гадаргын болон гүний усанд сөргөөр нөлөөлөх нөлөөлөл нь харьцангуй бага бөгөөд дайрганы ордын урдуур урсах Хангалын гол нь уулын баяжуулах үйлдвэр ажиллаж эхлэн хот бий болсноос хойш байнгын бохирдолтой байгаа болно. Голын бохирдлын гол эх үүсвэр нь уулын баяжуулах үйлдвэр ялангуяа хаягдлын сан, ил уурхай, цэвэрлэх байгууламж, дулааны цахилгаан станцын үнсэн сан зэрэг байгууламжын хаягдал ус болон үерийн ус гэж үздэг.

Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/

Бетон зуурмагийн үйлдвэрт ус ашиглах бөгөөд технологийн хаягдал ус гарахгүй юм. Үйлдвэрийн хэрэгцээний усаа өөрсдийн өрөмдмөл худгаас буюу гүний усаар хангаж байна.

3.3.6. Амьтны аймагт нөлөөлөх

“Тасагийн овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/-н үйл ажиллагаа нь тэсэлгээ хийх, бутлах, ачих, буулгах, ухаж малтах, түрэх, овоолох зэрэг ажлууд байх учраас амьтны аймагт дуу чимээний улмаас дүрвэж дайжих сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Дайрганы уурхай болон бетон зуурмагийн үйлдвэр орчны нутаг дэвсгэр нь олон жилийн өмнөөс Эрдэнэт үйлдвэрийн болон хотын орчны бүсэд хамрагдаж, нөлөөлөлд нь өртөгдөж ирсэн учраас амьтаны аймгийн төрөл зүйлийн хувьд маш бага, ойр орчимдоо ой мод байхгүй задгай тул шавьж болон мэрэгчид ч мөн адил цөөн тоотой байдаг байна.

3.4. Нийгэм эдийн засагт нөлөөлөх

“Тасагийн овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/

“Тасагийн овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/ нь тухайн дүүрэгт тодорхой тооны ажлын байр бий болгохоос гадна улс, аймаг, сум орон нутагт татвар, төлбөр хэлбэрээр төсвийн бүрдүүлэлтэнд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулдаг.

Нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн төрөл

Хүснэгт 2.2

Нөлөөллийн шинж чанар Үзүүлэлтүүд	Нөлөөллийн төрөл			
	Эерэг	Сөрөг	Шууд бус	Шууд
Ажлын байр нэмэгдэх	+			+
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх		+	+	
Үйлдвэрлэл аж ахуй хөгжих	+			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	+			+
Ядуурлыг бууруулах	+			+
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		+	+	
Иргэдийн шилжилт, хөдөлгөөн		+	+	

“Тасагийн овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/-н төслөөс нийгэм эдийн засагт эерэг шууд нөлөөлөл (57%) байгаа бол сөрөг шууд бус нөлөөлөл (43%)-тай байна. Иймд уг төсөл нийгэм эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэж үзсэн.

Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/

Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/ нь тухайн дүүрэгт тодорхой тооны ажлын байр бий болгохоос гадна улс, аймаг, сум орон нутагт татвар, төлбөр хэлбэрээр төсвийн бүрдүүлэлтэнд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулдаг.

Нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн төрөл

Хүснэгт 2.3

Нөлөөллийн шинж чанар Үзүүлэлтүүд	Нөлөөллийн төрөл			
	Эерэг	Сөрөг	Шууд бус	Шууд
Ажлын байр нэмэгдэх	+			+
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+			+
Үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих	+			+
Ядуурлыг бууруулах	+			+
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		+	+	

Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/-н төслөөс нийгэм эдийн засагт эерэг шууд нөлөөлөл (90%) байгаа бол сөрөг шууд бус нөлөөлөл байхгүй байна. Үүнээс эерэг, шууд нөлөөлөл нь 90%-тай байна. Иймд уг төсөл нийгэм-эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэж үзсэн.

3.5. Өрөмдлөг тэсэлгээний ажил

“Очир төв” ХХК нь орд газартаа өрөмдлөг тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ хийсний дагуу гүйцэтгүүлж байна. 2014 онд тус бутлан ангилах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж жилийн хүчин чадлыг 100,0 мян.м³ барилгын чулуу олборлохоор өсгөсний дагуу жил бүр өрөмдлөг тэсэлгээний ажлыг хийхээр тусгасан боловч 2014 оны 9-р сараас хойш өрөмдлөг тэсэлгээний ажил хийгдээгүй байна. Учир нь эдийн засгийн хямралаас хамаарч худалдан авалт буурснаар хүчин чадлынхаа хэмжээнд хүрч ажиллахгүй байгаа болно. 2017 онд уулын ажлын төлөвлөгөөнд өрөмдлөг тэсэлгээний ажлыг хийхээр тусгаж, 20.0 мян.м³ уулын цулд өрөмдлөг тэсэлгээний ажлыг гэрээгээр гүйцэтгүүлсэн. 2018 онд худалдан авалт буурсан тул өрөмдлөг тэсэлгээний ажлыг хийгээгүй. 2019 онд уулын ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу 20.0 мян.м³ уулын цулд өрөмдлөг тэсэлгээний ажил хийсэн, 2020, 2021, 2023, 2024 онуудад жилдээ 60.0 мян.м³ уулын цулд өрөмдлөг тэсэлгээний ажлыг гэрээгээр гүйцэтгүүлсэн.

2025 онд өрөмдлөг тэсэлгээний ажлыг гэрээгээр хийлгэхээр төлөвлөсөн.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Манай компани 2025 оны байгаль орчны менежментийн чиглэлээр дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллах болно. Үүнд:

- Хүрээлэн буй орчны тэнцлийг хадгалах, орчны агаарын бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүссэн хөрсний элэгдэл эвдрэлийг багасгах, байгаль орчинд сэргөөр нөлөөлөх нөлөөллийг бууруулах /мод бут тарих гэх мэт/
- Уурхайд усны емкость байрлуулж, насосаар шахаж үйлдвэрлэлийн талбай, зам талбайг шүрших замаар тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах.
- Орон нутгийн БОАЖГ-тай хамтран дүйцүүлэн хамгаалах ажил болон ногоон хөгжил хөтөлбөрт идэвхитэй оролцон ажиллах.
- Нутгийн унаган ургамлын биомассыг нэмэгдүүлэх, идэш тэжээлийн гинжин хэлхээг эвдэхгүйгээр үйл ажиллагаа явуулах, тухайн экосистемийн биологийн төрөл зүйлд хамгийн бага өөрчлөлт өгөх нөлөөллийг 0 түвшинд барих зэрэг зорилт тавин ажиллана.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Агаарын чанар	Тээврийн хэрэгслүүдийг оношлогоонд хамруулж, утаанд хяналт тавих, засварын гаражын утаа сорох, уурын зуухнаас ялгарах утаанд хяналт тавих	Материал үйлдвэрийн бааз	ш	-	-	627 000	жилд 1 удаа	
		Үйлдвэрлэлийн талбай, зам талбайг усаар шүршин замын тоосжилтыг бууруулах	Үйлдвэрлэлийн талбай, зам талбай	м ³	741.75	1550	1 150 000	Тоосжилт ихтэй саруудад усалгаа хийх	
2.	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Уурхайн олборлолт болон дайрга үйлдвэрлэх явцад ус ашиглахгүй. Бетон зуурмагийн үйлдвэрт ус ашиглах бөгөөд технологийн хаягдал ус гарахгүй юм. Үйлдвэрийн хэрэгцээний усаа өөрсдийн өрөмдмөл худгаас буюу гүний усаар хангаж байна.	-	-	-	-	-	-	
3.	Хөрсөн бүрхэвч	Хөрсөн бүрхэвч замын нөлөөгөөр доройтох тул олон салаа зам гаргахаас сэргийлэж, уурхайгаас засмал зам, вокзалын уулзвараас бетон зуурмагийн үйлдвэр хүртэлх шороон замуудыг автогрейдерээр хусаж, тэгшлэн сайжруулах	3-н замын уулзвараас уурхай хүртэлх зам, вокзалын уулзвараас бетон зуурмагийн үйлдвэр хүртэлх зам	км	1363636	2.2	3 000 000	жилд 1 удаа	
		Тээврийн хэрэгслүүдэд засвар үйлчилгээ хийх, машин техник шатах, тослох материал алдагдахаас сэргийлэх	Материал үйлдвэрийн бааз	-	-	-	-	тогтмол хийх	
4.	Газрын хэвлий	Уурхайн одоо үйл ажиллагаа явуулж байгаа талбай доторхи нөөцийг бүрэн аваагүй тул нөхөн сэргээлт хийхгүй							
5.	Ургамлан нөмрөг	Ургамлан нөмрөг замын нөлөөгөөр доройтох тул олон салаа зам гаргахаас сэргийлэж, уурхайгаас засмал зам, вокзалын уулзвараас бетон зуурмагийн үйлдвэр хүртэлх шороон замуудыг автогрейдерээр хусаж, тэгшлэн сайжруулах	3-н замын уулзвараас уурхай хүртэлх зам, вокзалын уулзвараас бетон зуурмагийн үйлдвэр хүртэлх зам	км	-	2.2	-	жилд 1 удаа	
6.	Амьтны аймаг	Эрдэнэт үйлдвэрийн болон хотын орчны бүсэд хамрагдаж, нөлөөлөлд нь өртөгдөж ирсэн учраас амьтаны аймгийн төрөл зүйлийн хувьд маш бага, ойр орчимдоо ой мод байхгүй задгай тул шавьж болон мэрэгчид ч мөн адил цөөн тоотой байдаг. Зэрлэг ан амьтан, айлуудын мал унах, дарагдах, дайруулахаас сэргийлж уурхайн эдэлбэр газарт тэмдэглэгээ хийсэн.							
	Нийт						4 777 000		

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт							
2.	Биологийн нөхөн сэргээлт							
3.	Татан буулгах, хаалтад бэлтгэх							
	Нийт							

MV-012161 тоот тусгай зөвшөөрлийн нийт 25 га талбайд нөөц нэмэгдүүлсэн ба уг талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй, дүйцүүлэн хамгаалалтын ажлыг жил болгон гүйцэтгэнэ.

ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Баян-Өндөр сумын Говил багийн нутаг дэвсгэр дэх 7 булгийн эхийг үргэлжлүүлэн сэргээн тохижуулах, хамгаалах					515 000	жилд 1 удаа	
2.	Ногоон төгөл байгуулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин оролцох ажлын хүрээнд улиас, бургас моднуудыг тарих.		Эрдэнэт шинэ хаалга буюу А1001 авто замын дагуу 3-н замын пост хүртэл ногоон зурвас байгуулж тарих. 2025 онд 0.3 га талбайд тарих.	500	12 500	6 250 000		
3.	Тарьсан модыг хамгаалж төмөр бетон шонтой өргөст торон хашаа барих.			335,5	20 000	6 710 000		
4.	Баян-Өндөр сум Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын зүүн урд энгэрт биологийн нөхөн сэргээлт хийх.		1 га талбайд хар шороон хөрсөөр хучилт хийх, үр цацах			10 325 000		
	Нийт					23 800 000		

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус ордын уурхайн нөлөөллийн бүсэд айл өрхийн өвөлжөө, зуслан, гар худаг байхгүй болно.

ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих орчмын нутаг дэвсгэр түүх, соёлын дурсгалт зүйлс болон тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэс, хамгаалалтын бүсэд ордоггүй. Энэ орчимд тусгай хамгаалалтанд авахаар төлөвлөж буй объект болон түүх, соёлын дурсгалт зүйлс байхгүй болно.

АРАВ. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Талбай дээр түлш асгарах	Түлш зөөврөөр цэнэглэх машинд засвар үйлчилгээ хийх	Асгарсан шингэнийг газрын гадаргуу дээр тогтоон барих. Асгарсан шатахуун дээгүүр машин техник явах, улмаар бохирдлын хүрээ тэлэхээс сэргийлэх. Асгарсан шингэнийг идэвхгүй бодисонд шингээх. /элс, шороо гэх мэт/		-	-	Засвар үйлчилгээг тогтмол хийх	
2.	Уурхай болон хотхонд гал гарах үед	Гал унтраах хороор хангах	Тухайн гал цахилгаанаас үүсэлтэй бол өөрт аюулгүй тохиолдолд цахилгааныг эх үүсвэр дээр нь буюу ерөнхий шийтээр унтраах. Хамгийн ойр байгаа галын хорыг ашиглаж галыг унтраах.		-	-	Галын хор байгаа эсэхэд байнга хяналт тавих	
3.	Газар хөдлөлт	-	Хамгийн аюул осол багатай газар хорогдох ба цахилгааны шон, тоног төхөөрөмжүүдээс аль болох хол байх хэрэгтэй.		-	-	-	
4.	Ажлын мөргөцөг үерийн усны аюулд автах	Үерийн ус орж ирэхээс сэргийлж шуудуу татах	Аюултай бүсийн хязгаар тогтоон орохыг хориглосон тэмдэг тавина.		-	-	Ус урсах шуудууд тогтмол үзлэг, цэвэрлэгээ хийх	
5.	Доголын хана нурах	Уурхайн хананд үзлэг хийх	Аюултай бүсийн хязгаар тогтоон орохыг хориглосон тэмдэг тавина.		-	-	Тогтмол үзлэг хийх	
	Нийт							

АРВАН НЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг ангилан ялгаж дахивар хог хаягдлыг орон нутгийн дахивар цуглуулах, тээвэр ложистикийн төвд өгөх, бусад хогыг тээвэрлэн дарж устгуулах, “Байгаль хамгаалах намрын сарын аян” ажлын хүрээнд цэвэрлэгээ хийх.	Уурхай, материал үйлдвэрийн бааз, голын гольдролын дагуу	м ³	11500	74.3	854 000	Жилд 1 удаа	
2.		Хогийн цэг, 00-н ойр орчим ариутгал хийх. офиссын ажилчдын өрөөнд ариутгал халдваргүйжилт хийх	Материал үйлдвэрийн бааз, уурхай	-	-	-	1 260 000	Жилд 28 удаа	
3.	Барилгын	Барилга угсралтын ажлаас гарсан төмөр бетон суурийн хог хаягдал	Барилгын ажлын талбай	м ³	20 000	180	3 600 000		
4.	Аюултай, хортой	Ашигласан тос, тосолгооны материалыг аюултай хог хаягдлын үүсгэгчийн бүртгэлээр ангилан ялгаж “Мон Пити Ойл” ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлэх.	Материал үйлдвэрийн бааз, уурхай	л	100	1000	100 000	Жилд 1 удаа	
	Нийт						5 814 000		

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
	“Тасагийн Овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/							
1.	Орчны агаарын чанар	1.Ажилчдын байр 2.Бутлуурын дэргэд 3. Ашиглалтын талбайн хойд талд 4. Хогийн цэг	Жилд 2 удаа	4	60 000	480 000		MNS 17.2.5 12:88 MNS 17.2.5 11:88
2.	Хөрсний химийн шинж	1.Ажилчдын байр 2.Бутлуурын дэргэд 3. Ашиглалтын талбайн хойд талд 4. Хогийн цэг	Жилд 2 удаа	4	60 000	480 000		MNS 3310:1991 MNS 3307:1991

Бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/							
3.	Орчны агаарын чанар	1. Бетон зуурмагийн узель 2. ШТС 3. Уурын зуух	Жилд 2 удаа	3	60 000	360 000	MNS 17.2.5 12:88 MNS 17.2.5 11:88
4.	Хөрсний химийн шинж	1. Бетон зуурмагийн узель 2. ШТС 3. Уурын зуух	Жилд 2 удаа	3	60 000	360 000	MNS 3310:1991 MNS 3307:1991
5.	Усны шинжилгээ		Жилд 1 удаа	2	50 000	100 000	
	Нийт					1 780 000	

АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 4-5	Сар 6-8	Сар 10		
	1	2	3	4	5	6	7
1.	БОМТөлөвлөгөө боловсруулах.	-	11-р сард			Т.Энхтуяа	
2.	Тээврийн хэрэгслүүдийг оношлогоонд хамруулж, утаанд хяналт тавих, засварын гаражын утаа сорох, уурын зуухнаас ялгарах утаанд хяналт тавих	627 000	4-р сард			Л.Туулбаатар	
3.	Нийт ажиллагсдыг цуглуулж байгаль орчныг хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар хурал зохион байгуулах.	-	4-р сард			С.Саранцэцэг	
4.	Хогийн цэг, 00-н ойр орчим ариутгал хийх, офиссын ажилчдын өрөөнд ариутгал халдваргүйжилт хийх.	1 260 000	4-10-р сард			Ч.Санжжав	
5.	Барилга угсралтын ажлаас гарсан төмөр бетон суурийн хог хаягдлыг зөөн цэвэрлэх.	3 600 000	4-10-р сард			Ч.Санжжав	
6.	Уурхайгаас засмал зам хүртэлх шороон зам, вокзалын уулзвараас бетон зуурмагийн үйлдвэр хүртэлх шороон замуудыг автогрейдерээр хусаж, тэгшлэн сайжруулах.	3 000 000	5-р сард			Ч.Санжжав	
7.	Ногоон төгөл байгуулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин оролцох ажлын хүрээнд улиас, бургас моднуудыг тарих.	6 250 000	5-р сард			Т.Энхтуяа	
8.	Тарьсан модыг хамгаалж төмөр бетон шонтой өргөст торон хашаа барих	6 710 000	5-р сард			Т.Энхтуяа	
9.	Баян-Өндөр сум Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын зүүн урд энгэрт биологийн нөхөн сэргээлт хийх.	10 325 000	5-р сард			Ч.Санжжав	


“Очир Төв” ХХК, “Тасагийн Овоо” уурхай /бутлан ангилах үйлдвэр/ болон бетон зуурмагийн үйлдвэр /уурын зуухтай/ төслүүдийн, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025 он

10.	Харьяа баг, хорооны ИНХ-д оролцох	-		6-р сард		Т.Энхтуяа, С.Саранцэцэг	
11.	Тоосжилт дарахаар усалгаа хийх.	1 150 000		6-8-р сард		Ч.Санжжав	
12.	Орчны хяналт шинжилгээг хийлгүүлэх.	1 780 000		5, 10-р сард		Т.Энхтуяа	
13.	Баян-Өндөр сумын Говил багийн нутаг дэвсгэр дэх 7 булгийн эхийг үргэлжлүүлэн сэргээн тохижуулах, хамгаалах	515 000			10-р сард	Т.Энхтуяа, Ч.Санжжав	
14.	Ашигласан тос, тосолгооны материалыг аюултай хог хаягдлын үүсгэгчийн бүртгэлээр ангилан ялгаж “Мон Пити Ойл” ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлэх.	100 000			10-р сард	Ч.Санжжав	
15.	Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг ангилан ялгаж дахивар хог хаягдлыг орон нутгийн дахивар цуглуулах, тээвэр ложистикийн төвд өгөх, бусад хогыг тээвэрлэн дарж устгуулах, “Байгаль хамгаалах намрын сарын аян” ажлын хүрээнд цэвэрлэгээ хийх.	854 000			10-р сард	Т.Энхтуяа	
16.	БОМТ-ний гүйцэтгэлийн тайланг боловсруулах.	-			10-р сард	Т.Энхтуяа	
	Нийт	36 171 000					

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Харьяа баг, хорооны ИНХ	Танилцуулж, санал авах	“Тасагийн Овоо” уурхайн талаарх танилцуулга	2025.06.05	-	Т.Энхтуяа, С.Саранцэцэг	Говил багийн ИНХ-ын танхим
2.	Сум, дүүргийн Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, сонирхогч ТББ-ууд	Тайлангаар танилцуулж бичгээр санал авах	БОМТ-ийн хэрэгжилтийн талаарх бүрэн тайлан	2025.10.25	-	Т.Энхтуяа, С.Саранцэцэг	Орхон аймгийн БОГ
3.	Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага	Тайлангаар танилцуулах	БОМТ-ийн хэрэгжилтийн талаарх бүрэн тайлан	2025.12.10	-	Т.Энхтуяа, С.Саранцэцэг	БОАЖЯ
	Нийт						

Хавсралт 1



Хавсралт 2

